ДОРНОД АЙМАГ
БАЯНТҮМЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 06 өдөр Дугаар 11/01 Цагаан дэрс

Сумын 2026 оны төсөвт нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Сумын 2026 онд зарцуулах урьд оны үлдэгдэлийг 515,836.4 мянган төгрөгөөр баталсугай.

Хоёр. Сумын 2026 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 515,836.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчид дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай.

/Мянган төгрөгөөр/

2.1	Засаг дарга	Батлагдсан дүн	Нэмэгдэх дүн	Нийт дүн
2.1.1	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	1,864,290.6	515,836.4	2,380,127.0
2.1.2	Сумын орон нутгийн хөгжлийн сан	1,864,290.6	515,836.4	2,380,127.0

Гурав. Сумын 2026 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар өөрчлөлт оруулсугай.

Урьд оны үлдэгдлээс санхүүжих дүн: 515,836.4 мянган төгрөг

Үүнээс: Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл:
515,836.4 мянган төгрөг

Дөрөв. “Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын өөрчлөлт”-ийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Ж.БАТЧУЛУУН